



Тогтвортой ноос ноолуурын эвсэл (ТННЭ) нь малчдын хотноос эхлээд жижиглэнгийн худалдаачид хүртэл ноолуурын нийлүүлэлтийн өргөтгөсөн сүлжээтэй хамтран ажилладаг ашгийн бус олон улсын байгууллага юм. Бидний алсын хараа нь байгаль орчинд ээлтэй, мал амьтдын тав тухтай амьдрах орчныг хангасан, малчдын баталгаат амьжиргааг дэмжсэн ноолуурын үйлдвэрлэлийг бий болгох болгох явдал юм.

Ноолуурын нийлүүлэлтийн сүлжээн дэх тогтвортой байдлын гол эрсдэлүүдийг авч үзэх, нотолгоонд суурилсан, тогтвортой байдлын стандартыг хангасан SFA Кашимер Стандартыг хэрэгжүүлэх нь манай байгууллагын 2030 он хүртэлх стратеги төлөвлөгөөний гол түлхүүр билээ. Энэ стандарт нь ноолуур үйлдвэрлэгч янз бүрийн бүс нутаг, болон системд тогтвортой мөрдөгддөг дэлхийн стандарт ба шинэчилж сайжруулсан стандарт нь үр нөлөөг үнэн зөв, тодорхой, үнэмшилтэй хэмжих, ил тод мэдэгдэл гаргах боломжийг олгох зорилготой юм.

### **Яагаад стандартыг шинэчлэх хэрэгтэй вэ?**

ТННЭ нь мал аж ахуй, бэлчээр ашиглах, цэвэр ноолуур боловсруулах зохистой дадлуудыг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь 2018 оноос эхлэн Монгол болон Хятад улсад тодорхой үе шаттайгаар хэрэгжиж байна. Туршилтын загвар төслүүд болон эдгээр зохистой дадлуудыг хэрэгжүүлснээр ноолуурын үйлдвэрлэл, нийлүүлэлтийн чухал асуудлууд, тэдгээрийг бүртгэх, баталгаажуулах, хянахад шаардлагатай удирдлагын тогтолцооны талаар илүү гүнзгий ойлголттой болох боломжийг олгосон.

2022 онд дээрх гурван зохистой дадлуудыг дэлхийн нэг стандарт болгон нэгтгэх саналыг ТННЭ дэвшүүлж байна. SFA Кашимер Стандарт нь ижил төстэй боловч бага зэрэг ялгаатай зохистой дадлуудыг бүс нутгуудад хэрэгжүүлэхээс зайлсхийсэн гүйцэтгэлд суурилсан, нөлөөллийн баримжаатай дэлхийн стандарт юм. Энэхүү стандарт нь ТННЭ-ийн 2030 он хүртэлх стратеги төлөвлөгөөтэй уялдсан ба ноолуурын үйлдвэрлэл, малчдын амьжиргаагаар холбоотой асуудлыг илүү өргөн хүрээнд шийдвэрлэхийн тулд зохистой хөдөлмөр, менежмент болон байгалийн ширхэгтийн чанарын зарчмуудыг цогц байдлаар авч үздэг.

### **Шинэ стандарт ямар байх вэ?**

Шинэ стандарт нь ямааны арчилгаа маллагаа, байгалийн нөөц, ширхэгтийн чанар , зохистой хөдөлмөр, менежмент гэсэн дараах таван бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

## Зарчмууд



Ямааны  
Арчилгаа,  
Маллагаа



Байгалийн  
Нөөц



Зохистой  
Хөдөлмөр



Ширхэгтийн  
Чанар



Менежмент

- Зарчим бүр нь сэдэв, зорьж буй үр дүн, шалгуур болон гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээс бүрдэнэ
- Улс орон бүр өөрийн бүс нутаг, хууль тогтоомж, ёс заншилтай холбоотой нөхцөл байдалд тохирсон удирдамжтай байх болно

Зарчим болон шалгуур үзүүлэлтүүд нь мал амьтад, хүрээлэн буй орчин болон малчдын хоршоод нь ноолуур үйлдвэрлэх явцад эерэг, хэмжигдэхүйц нөлөө үзүүлэхэд чиглэдэг байна.

Эдгээр зарчмууд нь байгаль орчинд ээлтэй, нийгэм, эдийн засгийн үр ашигтай ноолуурын үйлдвэрлэлийн гол түлхүүр элементүүд юм.

Зорьж буй үр дүн гэдэг нь богино болон дунд хугацааны явцад хүлээгдэж буй эерэг үр дүн аль эсвэл стандартыг хэрэгжүүлснээр гарах үр нөлөө юм.

Шалгуур болон гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь стандартыг мөрдүүлэх болон зарчим хэрэгжсэн эсэхийг дүгнэх байдлаар (баталгаажуулалт, аудит, нөлөөллийг хэмжих үйл ажиллагаануудаар) хангагдаг.

### Та хэрхэн хувь нэмрээ оруулах вэ?

Бид хүн бүрийг SFA Кашимер Стандартын агуулга, бүтцийн талаар санал хүсэлтээ ирүүлэхийг урьж байна. Энэ нь оролцогч талуудын ирээдүйн тэнцвэрийг хангах зорилгоор нийлүүлэлтийн сүлжээн дэх бүх өөр өөр газруудаас эхлээд олон янзын үйлдвэрлэлийн салбаруудыг оролцуулах боломжоор хангадаг.

**Онлайн санал хүсэлт:** Энэхүү судалгааг бөглөнө үү – Та уг стандартын зарчмын талаар ерөнхийд нь юм уу тодорхой аль нэг хэсэгт нь санал хүсэлт өгч болно. Санал, хүсэлт өгөхдөө нэр болон албан байгууллагаа нэрээ нууцлан өгч болно. Хариултыг хувь хүн нэрээ нууцлаж, мөн өөрийн байгууллагыг төлөөлөн өгч болно.



Мөн та илүү тодорхой санал, хүсэлт болон шаардлагатай барим бичгийг [standards@sustainablefibre.org](mailto:standards@sustainablefibre.org) цахим хаят илгээж болно.

Бид илүү уг стандарттай хамааралтай эсвэл хэлэлцэж буй бодит асуудлыг сонирхож буй оролцогч талууд, төрийн бус байгууллагууд, эрдэмтэн судлаачдын санал, хүсэлтийг авах сонирхолтой байна.

Бидэнд ирсэн бүх санал, хүсэлт гаргагчдын нэрийг нууцалж, санал хүсэлт болон асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тоймлон дүгнээд олон нийтэд нээлттэй болгоно.

### **Дүгнэлт хэрхэн явагддаг вэ?**

Стандартын дүгнэлт нь ТННЭ-ийн стандарт тогтоох журмын дагуу явуулдаг бөгөөд энэ журам нь Олон Улсын Нийгэм-Байгаль Орчны Итгэмжлэл ба Тэмдэгтийн Байгууллагын (ISEAL) зохистой дадлыг дагаж мөрддөг.

- Нийгмийн болон байгаль орчны стандартыг тогтоох
- Нийгмийн болон байгаль орчны стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах
- Нийгмийн болон байгаль орчны стандартын тогтолцооны нөлөөллийг үнэлэх

Бие даасан зөвлөл нь зарчим, сэдэв, шалгуур үзүүлэлтийг багтаасан загвар стандартын төслийг боловсруулж, анхны санал хүсэлтүүдийг нэгтгэх зорилгоор эхний олон нийтийн хэлэлцүүлгийг 2021 оны аравдугаар сард явуулсан.

Уг хэлэлцүүлгийн дараа 2022 онд Амьтдад харгис хэрцгий хандахаас урьдчилан сэргийлэх хааны нийгэмлэг (RSPCA), Мал амьтны арчилгаа маллагааны олон улсын хамтын ажиллагааны хороо (ICCAW), Элгин Жонстонс, Жон Льюис зэрэг олон улсын байгууллагуудын саналуудыг оруулсан илүү нарийн хэлэлцүүлэг явагдсан.

2022 оны 9-р сард зохион байгуулагдсан “Байгалийн ширхэгт” олон улсын хуралд Монголын малчид, хоршоод болон үйлдвэрлэгч байгууллагууд биечлэн оролцож шинэ стандартын талаарх мэдээлэлтэй танилцсан. Энэ үйл ажиллагааг манай байгууллагын Хятад дахь салбар болох Мал амьтны арчилгаа маллагааны олон улсын хамтын ажиллагааны хороо ICCAW нь мөн хэрэгжүүлэн түгээн дэлгэрүүлэх ажлыг гүйцэтгэсэн болно.

## Ноолуурын Стандартын Өөрчлөлт 2022-2023



### Шийдвэр гаргах үйл явц:

Санал хүсэлтийг харгалзан үзэж, шаардлагатай бол өргөтгөсөн хэлбэрээр явуулна. Стандарт тохируулах, сайжруулах хороо (SSIC) нь манай стандарт тогтоох журмын дагуу стандартын агуулгын эцсийн шийдвэрийг гаргана.

Хоёр дахь хэлэлцүүлгийн дараа бидэнд ирсэн бүх санал, хүсэлт гаргагчдын нэрийг нууцалж, санал хүсэлт болон асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тоймлон дүгнээд олон нийтэд нээлттэй болгоно.